



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 1/31

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 34 дүгээр зүйлийн 2.1, 34.1.2, 34.2.2, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 06 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/194 дүгээр захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Онцгой комиссын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан ажиллагааны бэлэн байдлыг хангуулах ажлын хүрээнд байгууллагын түр штабт ажиллах албан хаагчдын нэрсийг 1 дүгээр, цагийн байдалд бэлэн ажиллах мэргэжлийн багийг 2 дугаар, байгууллагын газар хөдлөлт болон гамшгийн үеийн бэлэн байдлыг хангуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг 3 дугаар, ажиллах чиг үүргийн удирдамжийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Гамшгаас хамгаалах 24 цагийн түр штабын бэлэн байдал, мэргэжлийн багийн үйл ажиллагааг уялдуулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс (Б.Найрамдал)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА


С.ТӨМӨРДУЛАМ

